

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗРЫН
ЗУРГААДУГААР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
/2020.06.01-2020.06.15/

2020 оны 06 дугаар сарын 16

Даланзадгад хот

Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газар нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хооронд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1. Виз, зөвшөөрлийн үйл ажиллагааны чиглэлээр:

Тайлант хугацаанд “Монгол Улсын Виз олгох журам”-ын 6.2-т заасны дагуу ачаа тээвэрлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Камелнис ложистик” ХХК-ийн БНХАУ-ын 2 иргэн, “Качнис ложистик” ХХК –ийн 1 иргэн, БНХАУ-ын 37 нийт 40 иргэний визийн сунгалтын материалыг бүрдүүлэн төв газарт хүргүүлж, холбогдох дансанд тэмдэгтийн хураамжийн 4,392,000 төгрөгийг төвлөрүүлэн ажилласан.

Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд

Байгууллагын даргын 2020 оны 01,03,04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг долоо хоногийн даваа гариг бүр холбогдох нэгжид хүргүүлэн ажиллаж байна.

Байгууллагын даргын “Хариуцлагатай эргүүл, жижүүрийн ажиллах хуваарь батлах тухай” 2020 оны А/125 дугаар тушаалын дагуу хуваарьт гарсан албан хаагчид заагдсан өдрүүдэд хариуцлагатай жижүүрийг хийж төв газарт тухай бүр нь мэдээг өгч ажилласан бөгөөд гарсан зөрчил байхгүй болно.

Албан хаагчдын 02 дугаар улирлын гүйцэтгэлийн тайланг гаргуулан ажиллаж байна.

1.1.Өргөдөл, гомдлын мэдээ

- Бүртгэсэн өргөдөл, гомдлын тоо /Хүлээн авсан/-0
- Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо-0
- Шилжүүлсэн өргөдөл, гомдлын тоо-0
- Шийдвэрлэлтийн шатанд байгаа болон хугацаа сунгасан өргөдөл, гомдлын тоо-0
- Баримт бичиг боловсруулалтын хүрээнд /Тушаал-0/
- Төв газарт явуулсан бичиг /илтгэх хуудас-3/
- Явуулсан бичиг /албан тоот-3/
- Бусад байгууллагаас ирсэн бичиг-4
- Боомт орон нутагт явуулсан дотоод албан бичиг-0

1.2.Санхүү, хангалт үйлчилгээний чиглэлээр:

Энэ оны 06 дугаар сард 39,477,400 төгрөгийн санхүүжилт авч нийт 22 албан хаагчийн урьдчилгаа цалинд 6,400,000 төгрөгийг олгон ажилласан байна.

Тус газрын 2020 оны 05 дугаар сарын шилэн дансны мэдээллийг цахим сайтад байршуулж тоон мэдээг дараа сарын 02-ны дотор холбогдох нэгжид хүргүүлж ажилласан.

1.3.Мэдээлэл технологийн чиглэлээр:

Газрын хэмжээнд сүлжээний хэвийн байдлыг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд албан хаагчдаас сүлжээ тасалдсан, компьютерийн хэвийн бус ажиллагаатай холбоотой нийт 2 дуудлага ирүүлснийг тухай бүр засч сайжруулан ажилласан.

Хоёр. Бусад

2.1 Шинэ коронавирусын /ковид-19/ дэгдэлт ихэссэнтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс, Өмнөговь аймгийн онцгой комисс болон байгууллагын даргын гаргасан шийдвэрүүдийг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна. Тухайлбал, албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор халуун чацаргана, витамин, гар ариутгах бодисоор ханган, албаны өрөөнүүдийн цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтлийг сайжруулан ажиллаж байна.

Мөн байгууллагын даргын гаргасан албан даалгаврын биелэлт, уг вирусээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн гаргаж холбогдох нэгжид хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.

ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗАР